



УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 12/01

Улаангом

“НЭЭЛТТЭЙ УВС АЙМАГ” хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.17 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”, 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 419 дүгээр тогтоол, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх “Таван жилийн үндсэн чиглэл”, аймгийн Засаг даргын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үзэл баримтлалд тулгуурласан аймаг орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, нийгэм, эдийн засаг, техник, технологи, үндэсний үйлдвэрлэлийн ололт амжилт, нөөц боломж, түүх, соёл, зан заншил, уламжлал, оюун санааны үнэт зүйлсийг шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд мэдээлэн сурталчлах “Нээлттэй Увс аймаг” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хот, хөдөөгийн сэргэлт “Нээлттэй Увс аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. “Нээлттэй Увс аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгаж, төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлж ажиллахыг, аймгийн Засаг дарга (Ч.Чимэд)-д даалгасугай.

4. Хот, хөдөөгийн сэргэлт “Нээлттэй Увс аймаг” хөтөлбөрийн биелэлт, үр дүнг нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг аймгийн Засаг дарга (Ч.Чимэд)-д даалгасугай.

5. Энэхүү хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Аюушжав)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТБОЛД